

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2019 оны 7 сарын байдлаар/

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	71039	66899	46442	23455	2124	209959
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	27988	23375	16173	2497	1811	71844
3	Идэвхтэй хяналтын үзлэг	6634	12897	11118	1356		32005
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	18976	13364	7775	5135	298	45548
5	Нийт төрөлт	737	173				910
6	Хэвтэн эмчлүүлэгчид	4824	2979		1518	20	9341
7	Нас баралт	21	112	69		1	203

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 209959 хүнд үзлэг шинжилгээ хийсний 49.4%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 9341 хүнийг 61352 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.5 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 7 сарын байдлаар 45548 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7850 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 7 сарын байдлаар 727 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 39 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 103 тохиолдлоор буурч, осол гэмтлийн нас баралт 13-р тохиолдлоор өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын 30.7%/12/нь амиа хорлож/Бд-1,Гт-2,Мо-1,Мн-2,Но-1,Сэ-1,Хх-1,Хб-1,Эу-2/ 33,3%/13/нь зам тээврийн осол,/Бо-1,Но-2,Сэ-1,Хб-2,Хү-2,ЦЦ-1,Эх-1,Эу-1,БОЭТ-2/, 30,7%/12/ нь бусад ослоор/хөлдсөн-8-Сэ-2,Хб-1,Хх-1,Цц-2,Шб-1,Эх-1,архины хордлого-Гт-2,Эх-1,зодуулсан-Но-1/ 6,6%/2/бусдад хорлогдсон-/Но-1/,Хб-1/ тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсадын 74,3% нь эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 63,3% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 66,6%/6/ хүний /өөрийгөө буудсан-1, хөлдсөн-1,бусдад хорлогдсон-1, архины хордлого-1 нийт-4 хүн/хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. Нийт осол гэмтлийн нас баралт:Гт-3/амиа хорлосон-1,хөлдсөн-1,зам тээврийн ослоор-1/,Мо-1/амиа хорлосон-1/,Мн-1/амиа хорлосон-1/,Но-3/зам тээврийн осол-2, бусдад хорлогдсон-1/,Сэ-4/хөлдсөн-2,амиа хорлосон-1,зам тээвэр-1/,Хх-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Хб-3/амиа хорлосон-1,хөлдсөн-1,бусдад хорлогдсон-1/,Хү-2/зам тээврийн осол-2/,ЦЦ-1/зам тээврийн осол-1/Эх-

- 2/архинд хордсон-1,хөлдсөн-1/Эу-5/амиа хорлосон-2,зам тээвэр-1, хөлдсөн-2/БОЭТ-3/бусдад хорлогдсон-1,зам тээвэр-1,юманд цохигдсон-1/
5. Оны гарсаар 203 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 19.2% нь осол гэмтлээр, 25.1% нь хорт хавдраар 5.4% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт/Бо-1,Но-1,Хх-3,Цо-1,Шб-2,Өо-1,Эх-1,Эу-1/ зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 6.4% /Хб-5,Гт-4,Мн-1,Цц-1,Бг-1/нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
 6. Нялхсын эндэгдлийн 18/Гт-4,Хб-6,Цц-2,Мн-1,Хү-1,Эх-1,Бг-1,Нн-2,/тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 19,7 байна.
 7. Түргэн тусламжийн 7426 дуудлагад явж үйлчилсний 1091/14.6%/ нь алсын дуудлага, 415/5,5%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 95.8% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
 8. 7 сард 4444 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 64% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 9 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байна.
 9. Нийт 910 эх төрж 914 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 44 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 5,8% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бо-2,Бу-2,Гт-3,Мн-3,Но-3,НН-1,Сэ-2,Хб-1,Хх-3,Хү-1,Цц-4,Шб-7,Өо-13,Эх-4,Бг-3/.
 10. 7 сарын байдлаар 437 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 480 байгаа нь өнгөрсөн оноос 2% буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт 6%/Бд-1,Бу-3,Мо-1,Мн-1,Но-2,Нн-1,Сэ-1,Хб-4,Хх-2,Хү-1,Цц-1,Шб-3,Өо-1,Эх-3,Бг-2/ байна.
 11. Он гараад 256 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 193 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 20%-г салхинцэцэг, 8,5%-г улаанэсэргэнэ өвчин, 53,5%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
 12. ЭЭСангуудад нийт 10581 жор ирсний 50.2%/5311/нь ЭМДаатгалын, 0,1%/11/ мансууруулах эмийн, 2% /202/ сэтгэц нөлөөт эмийн, 47.8% /5067/ нь энгийн эмийн жор байсан ба 1,1% /121/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 73,5% байна.
 13. БОЭТөвд 21 эндэгдэл тохиолдож 5 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 75% тай байна. Үндсэн оношийн зөрөө 2%.